

АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДЛЫН

2014 ОНЫ ЭХНИЙ 1 САРЫН МЭДЭЭЛЭЛ

Мал онд оролт: Мал сүргийн онд оролт 99.92 хувьтай байгаа нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 11.2 дахин бага байгаа ба 422 мал хорогджээ.

Үнэ: Хөдөө аж ахуйн гол нэрийн бүтээгдэхүүн, малын үнэ сүүлийн сард харьцангуй тогтвортой байсан ба малчдын орлогын зонхилох хувийг бүрдүүлдэг ямааны ноолуурын үнэ түүвэр судалгаанд сонгогдсон Алтай хотод сарын эцэст доорхи ханштай байлаа.

Сар	I
1 кг ноолуурын үнэ \мянган төгрөг\	60.0

Гол нэрийн барааны үнэ сумдад зах зээлийн зайнаас хамаарч харилцан адилгүй байгаагийн дээр аймгийн төвд гурил 1кг нь 900-1000, сайн чанарын шар, цагаан будаа 1900-2000, элсэн чихэр 1800, ногоон цай 5000-6500 төгрөгийн дундаж ханштай байна.

Аж үйлдвэр: Аж үйлдвэрийн салбарт 1 тэрбум 300.5 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 25,1 сая төгрөгөөр бага байна. Нийт үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийхээ 77.8 хувь буюу 1 тэрбум 12.1 сая төгрөгийн борлуулалт хийгдлээ.

Төсвийн орлого: Орон нутгийн төсөвт 1 тэрбум 977.4 сая төгрөг оруулж, төлөвлөгөөг 5 дахин, улсын төвлөрсөн төсөвт 46,3 сая төгрөг оруулж төлөвлөгөөг 73.6 хувиар тус тус биелүүлж, аймгийн төсвийн нийт орлого 2 тэрбум 23.8 сая төгрөг биелэлттэй байна.

Төсвийн зарлага: Аймгийн хэмжээнд 3 тэрбум 610.3 сая төгрөгийн зарлага санхүүжилт хийгдсэн нь төлөвлөгдсөн хэмжээнээс 91.4 хувийн биелэлттэй байна.

Орон нутгийн төсвийн байгууллагууд 12.8 сая төгрөгийн авлаатай, 2.7 сая төгрөгийн өглөгтэй байна.

Хүн ам: Аймгийн хэмжээнд 111 эх амаржиж 112 хүүхэд мэнд төрлөө. 1 хүртэлх насны хүүхдийн эндээдлийн 5 тохиолдол бүртгээгдсэн байна. Халдварт өвчний гаралт өмнөх оны мөн үеэс 5 тохиолдлоор нэмэгдсэн байна.

Ажилгүйдэл 1 сарын эцсийн байдлаар хөдөлмөр эрхлэхийг хүсч бүртгүүлсэн ажилгүйдчүүд 1241 болсны дотор 56.3 хувь буюу 699 нь эмэгтэйчүүд байна. Эдгээр бүртгүүлсэн ажилгүйдчүүдийн 327 нь дээд, 477 нь тусгай дунд, 270 нь бүрэн дунд, 87 нь суурь, 37 нь мэргэжлийн анхан шатны, 34 нь бага, 9 нь ямар ч боловсролгүй хүмүүс байна.